



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

## **МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ**

---

**ҮНДЭСНИЙ ТАВ ДАХЬ ИЛТГЭЛ  
2013**

---

**ХУРААНГУЙ**

---

Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилтуудын Хэрэгжилтийн Үндэсний Тав дахь Илтгэл 2013

Эдийн засгийн хөгжлийн яам

Улаанбаатар, Монгол Улс

2013 оны 9 сар

Илтгэлийг Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд бэлтгэсэн.

---

## АГУУЛГА

---

МХЗ-уудын хэрэгжилт: Монгол Улс хэрхэн хэрэгжүүлж байна?	4
Мянганы хөгжлийн зорилтууд: Тойм	5
Зорилго 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах	8
Зорилго 2: Бүх нийтээрээ анхан шатны боловсрол эзэмших	13
Зорилго 3: Жендерийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	14
Зорилго 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах	16
Зорилго 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах	17
Зорилго 6: Бэлгийн замын халдварт өвчин, Хүний дархлал хомсдлын вирус, Дархлалын олдмол хомсдол, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	18
Зорилго 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	21
Зорилго 8: Хөгжлийн төлөө дэлхийн нийтийн түншлэлийг хөгжүүлэх	25
Зорилго 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	28
Хэрэгжээгүй МХЗ-ууд: 2015 оноос хойш хэрэгжүүлэх зорилтууд	32
Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийн тоон мэдээлэл	35

## МХЗ-УУДЫН ХЭРЭГЖИЛТ: МОНГОЛ УЛС ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА?

Мянганы хөгжлийн зорилт	Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн
<b>МХЗ 1: ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ</b>					
Зорилт 1: Амьжиргааны доод түвшингөөс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах					
Зорилт 2: Хоол, тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах					
Зорилт 3: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах					
Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах					
<b>МХЗ 2: БҮХ НИЙТЭЭРЭЭ АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ</b>					
Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох					
<b>МХЗ 3: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ</b>					
Зорилт 6: 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах					
Зорилт 7: Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах					
Зорилт 8: Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх					
<b>МХЗ 4: ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ</b>					
Зорилт 9: Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах					
<b>МХЗ 5: ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ</b>					
Зорилт 10: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах					
<b>МХЗ 6: БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДЛЫН ВИРУС (ХДХВ), ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ (ДОХ), СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ</b>					
Зорилт 11: 2015 он гэхэд ХДХВ, ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх					
Зорилт 12: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах					
Зорилт 13: Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах					
<b>МХЗ 7: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>					
Зорилт 14: Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот, суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх					
Зорилт 15: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах					
Зорилт 16: 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах					
Зорилт 17: 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах					
<b>МХЗ 8: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</b>					

Мянганы хөгжлийн зорилт	Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн
Зорилт 18: Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх					
Зорилт 19: Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх					
Зорилт 20: Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх					
Зорилт 21: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах					
<b>МХЗ 9: ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ</b>					
Зорилт 22: Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох					
Зорилт 23: Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх					
Зорилт 24: Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх					

---

## МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД: ТОЙМ

---

2000 оны 9 дүгээр сард Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейд оролцсон 189 орны Засгийн газраас Мянган тунхаглалыг баталсан бөгөөд дэлхийн улс орны тэргүүнүүд даян дэлхийд энх тайван, хөгжил цэцэглэл болон шударга ёсыг тогтоохоор хамтран ажиллах амлалт авсан нь өмнө нь тохиолдож байгаагүй зүйл болсон юм. Хүний аж байдлыг сайжруулах болон ядуурлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг нэмэгдүүлэх, хүний эрх болон ардчилалыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл явцыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн даян дэлхийн эрхэм зорилгын хэрэгжилтийг хангахын тулд эдгээр амлалтыг Мянган Хөгжлийн Зорилт (МХЗ)-үүд болгон 2001 онд баталсан.

МХЗ-үүд нь Монгол Улсын бодлогын түвшинд тусгалаа олсон. Монгол Улсын Их Хурал (УИХ)-аас МХЗ-үүдыг хөгжлийн харьцуулах үзүүлэлт болгон 2005 онд баталсан бөгөөд 2008-2021 оны МХЗ-тод суурилсан Үндэстний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ын суурь болгон ашигласан. “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” есдүгээр зорилгыг шинээр нэмж тодорхойлсон цөөн орны нэг нь Монгол Улс бөгөөд ардчилсан засаглал, хүний эрхэд онцгой анхаарал хандуулснаар бусад МХЗ-үүдыг хангахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх юм. Монгол Улсын МХЗ-үүдэд 2008 онд дахин тодотгол хийж 9 зорилгын хүрээнд 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэй баталсан.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц хурдацтай өсч, дэлхийн зах зээл дээрх зэсийн үнийн өсөлт, алтны олборлолт нэмэгдсэнтэй холбогдон 2004-2008 оны жилийн дундаж өсөлт 9 орчим хувьд хүрсэн юм. 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын нөлөөг богино хугацаанд даван туулсны дараа эдийн засгийн өсөлт 2011 болон 2012 онд 2 оронтой тоонд хүрсэн. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2006 онд 1,300 ам.доллар байсан бол 2012 оны эцэст 3,035 ам.доллар болон өсч, Монгол Улс нь дунджаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтах болжээ.<sup>1</sup>

Гэвч улсын эдийн засгийн суурь нь хязгаарлагдмал хэвээр байна. Ашигт малтмалын түүхий эдийн экспорт нийт экспортын 80 хувийг эзэлж байгаа бөгөөд нийт ажиллах хүчний 3 хувь нь ажиллаж байгаа уул уурхайн салбар нь төсвийн орлогын 40 орчим хувийг бүрдүүлж байна. Боловсруулах салбар ДНБ-ий 11 хувийг эзэлж байгаа нь уул уурхайн салбараас ДНБ-д оруулж буй хувь нэмрийн тэн хагас орчимтой тэнцэж байна. Уул уурхайн бүтээгдэхүүнээс олох орлогоос ихээхэн хамааралтай эдийн засаг нь гадаад нөхцөл байдлын өөрчлөлт, хэлбэлзлийн нөлөөлөлд өртөхөд хүргэж байна.

Монгол Улсын хүний хөгжлийн индекс (ХХИ) 0.675 болсон нь дэлхийн 187 орноос 108 дугаар байранд орж, хүний хөгжил дундаж түвшинтэй орны ангилалд харъяалагдаж байна.<sup>2</sup> Ази, Номхон

---

<sup>1</sup> Орлогын ангилал нь Дэлхийн банкнаас нэг хүнд ногдох ДНБ-д үндэслэсэн тооцоо бөгөөд бага орлоготой (1,005 ам.доллараас бага), дунджаас доогуур орлоготой (1,006-3,875 ам.доллар), дунджаас дээгүүр орлоготой (3,976-12,275 ам.доллар), өндөр орлоготой (12,276 ам.доллараас дээш) гэж ангилдаг.

<sup>2</sup> НҮБХХ Хүний хөгжлийн илтгэл, 2013.

Далайн орнуудын хүний хөгжлийн дундаж индекс 0.683 байгаа нь Монгол Улсынхаас бага зэрэг их байна. Гэхдээ эдийн засгийн хөгжлөөрөө ойролцоо түвшингийн орнуудтай харьцуулахад Монгол Улсын ХХИ өндөр байна.

Ядуурлын түвшин 2010 онд 38.7 хувь байсан бол 2012 онд 27.4 хувь болж 11 нэгжээр бүүрчээ. Сүүлийн жилүүдэд ядуурлыг ихээхэн бүүрүүлж чадсан нь Засгийн газраас нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээл, хүн амын хүнсний хангамж, эх, нялхсын тусламж үйлчилгээний бодлогыг үр дүнтэй явуулсантай зүй ёсоор холбоотой гэж болно.

Гэвч эдийн засаг хурдацтай өсч буй орны хувьд ядуурлын түвшин нь хүлээн зөвшөөрөх боломжгүй өндөр түвшинд байсаар байна. Эрүүл мэнд болон бусад суурь үйлчилгээний хүртээмж хангалтгүй, байгалийн гамшигт өртөмтгий, ажил эрхлэх боломж хомс, бүс нутгийн хөгжлийн түвшин ялгаатай, олгож буй боловсрол нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцэхгүй байгаа байдал нь Монгол Улсын ядуурлын гол шалтгаан юм.

МХЗ-уудын хэрэгжилтийн 5 дахь Илтгэл (2013) нь МХЗ-уудын хэрэгжилтийг эдгээрийн зорилт болон шалгуур үзүүлэлтүүдийн гарсан үр дүн, МХЗ-уудын хүрээн дэх төрийн бодлогын өнөөгийн нөхцөл байдалтай холбон үнэлж, 2015 он гэхэд МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлсон. Түүнчлэн МХЗ-уудыг ханган ард иргэдийн аж амьдралыг сайжруулах талаарх амлалтаа Монгол Улсын Засгийн газар хэрхэн биелүүлж байгааг үнэлсэн үнэлгээг энэ тайланд харуулсан.

Энэхүү Илтгэл нь чиг хандлагын болон тэгш бус байдлын шинжилгээ, тэдгээрийн өөрчлөлт ба газар зүйн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон хэрэгжих боломжгүй шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэхэд саад болж буй хязгаарлах хүчин зүйлсийг тогтоож тэдгээр нь салбар хооронд болон зорилгуудын хүрээнд хэрхэн тархсаныг таниулсан. Түүнчлэн энэ Илтгэлд удаашралтай болон хэрэгжих боломжгүй шалгуур үзүүлэлтүүдийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газраас авах арга хэмжээний зөвлөмжүүд тусгагдсан.

### ***Илтгэлийг боловсруулах үйл явц***

Энэхүү Илтгэлийг Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ)-ны манлайлал дор оролцоог хангасан, зөвлөлдөх арга замаар бэлтгэв. Илтгэлийг боловсруулах үе шатанд оролцогч талууд зохих хувь нэмрээ оруулсан. Тоон мэдээллийн маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд ЭЗХЯ-аас 2013 оны 2-3 дугаар сард техникийн цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан Илтгэлийг бэлтгэх үйл явцыг эхлүүлсэн.

“Мянганы хөгжлийн зорилтуудын 2015 он хүртэлх хэрэгжилтийг эрчимжүүлэх” сэдэвт Үндэсний Зөвшилцөх уулзалтыг 2013 оны 3 дугаар сард зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт зориулж Суурь Илтгэлийн үнэлгээг үндэсний хоёр зөвлөхөөр хийлгэсэн.

Түүнчлэн 2013 оны 8 дугаар сард Илтгэлийн төслийг хэлэлцүүлэх үндэсний түвшингийн уулзалтыг зохион байгуулсан. Эцэслэн боловсруулахын өмнө Илтгэлийн төслийг холбогдох бүх яамд, агентлагууд болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, тэдний саналыг авсан болно.

### **Илтгэлийн үндсэн онцлогууд**

МХЗ-уудын хэрэгжилтийн 5 дахь Илтгэл нь хэд хэдэн үндсэн онцлогтой. Нэгдүгээрт, МХЗ-уудыг хангах үйл явцын үнэлгээг таван түвшингөөр хийсэн. Нийт зорилтын гуравны нэг (24-өөс 8) нь биелэх боломжтой эсвэл бүрэн биелсэн байна. Долоон зорилтын хувьд нэмэлт арга хэмжээ авч, тодорхой хүчин чармайлт гаргавал 2015 он гэхэд хэрэгжих боломжтой. Гурван зорилгын хүрээнд дөрвөн зорилт нь үлдсэн хугацаанд хэрэгжих магадлал бага, мэдээлэл болон арга зүйн асуудлаас шалтгаалан таван зорилтын хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

Илтгэлийн өөр нэгэн онцлог нь илтгэлийг боловсруулсан багынхан МХЗ-уудын хэрэгжилтэнд тулгарч буй шалтгаан, хүндрэлийг ядуурал их болон багатай сумдуудад очиж судалгаа хийсэнд оршино. Чанарын судалгааг ядуурлын түвшин өндөртэй Хангайн бүсийн 4 аймгийн 12 суманд хийлээ. Орон нутагт хийсэн энэхүү судалгаа нь нэгдсэн тоон мэдээллийн шинжилгээ болон хөтөлбөрийн хэрэгжилтэнд тулгарч буй саад бэрхшээлийн талаарх ойлголтыг сайжруулахад тус дэм болсон.

МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа хэдий ч тэдгээрийг хэрэгжүүлэх үйл явцад гадаад хүчин зүйлүүд ихээхэн нөлөө үзүүлсэн гэдэг нөхцөлтэйгээр энэ Илтгэлийг ойлгох нь зүйтэй.

Монгол Улсын даван туулах хөгжлийн сорилтууд хэвээр байгаа боловч сүүлийн жилүүдэд ажиглагдсан эдийн засгийн өсөлтийн үр дүнд хандивлагчдын санхүүжилт буурч, хандивлагчдаас баримтлах тэргүүлэх ач холбогдолд өөрчлөлт орсон. Энэ байдал нь хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд зориулан дайчлах эх үүсвэр, улмаар Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтэнд нөлөөлж магадгүй юм.

МХЗ-уудыг залгамжлах хүрээг боловсруулах, зөвшилцөх талаар дэлхий даяар хэлэлцэж байгаа үед 2015 он гэхэд МХЗ-уудыг хангах талаар үлдэж буй хугацаанд илүү түлхэц өгөх шаардлагатай байна.




---

## ЗОРИЛГО 1 ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ

---

*Зорилт 1 Амьжиргааны доод түвшингөөс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах*



Монгол Улс ядуурлын түвшинг 1995 оноос эхлэн тооцож байна. Арав гаруй жилийн хугацаанд (1995-1997/08 онуудад) ядуурлын түвшин 35.0-36.0 орчим хувьтай байв. Гэхдээ судалгааны дизайн (ядуурлын түвшинг тооцоход ашигласан аргачлал, хэрэглээний иж бүрдэл байгуулсан болон хэрэглээний сагс тооцсон аргачлал нь ялгаатай, мөн он тус бүрт шинээр ядуурлын шугам тооцсон)-аас шалтгаалан 2007/2008 оноос өмнөх ядуурлын түвшингийн тоонуудыг харьцуулах боломжгүй байна. Ядуурлын тоон мэдээллийн маргааныг 2012 онд шийдсэнээр, одоо бүх оролцогч талууд ядуурал Монгол Улсад 2010 онд 38 гаруй хувь байсан бол үүнээс хойш тогтвортой буурч, 2012 оны байдлаар нийт хүн амын 27.4 хувь нь ядуу байна гэдэгтэй санал нэгддэг болсон.

Эдийн засгийн өсөлтийн хурд сүүлийн гурван жилд нэлээд нэмэгдэж, Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших хугацаанд эдийн засгийн өсөлтийн дээд түвшинд хүрсэн байна. Гэсэн хэдий ч нийт хүн амын дөрөвний нэгээс их нь ядуу байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг хүн амын ядуурлыг дорвитой бууруулахад чиглүүлж чадахгүй байгаагийн илрэл юм.

Монгол Улсад ядуурлын гүнзгийрэлт 1995-2010 оны хооронд харьцангуй тогтвортой 10 орчим хувьтай байсан бөгөөд, 2011 онд 9.2 хувь, 2012 онд 7.1 хувьд хүрч буурчээ. Ядуурлын гүнзгийрэлт буурч байгаа нь ядуу хүмүүс ядуурлын шугамын ойролцоо очиж байгааг харуулж байна. Бүс нутаг, аймгуудын хооронд ядуурлын гүнзгийрэлт ялгаа ихтэй байна.

Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувь 2002-2010 оны хооронд 7.5 хувиас 7.9 хувь хүртэл өссөнөөс хойш 2012 онд бага зэрэг буурч, 7.7 хувь болсон байна. Энэ үзүүлэлтээр 2015 онд 11 хувь хүрэх зорилт биелэх магадлал бага байна. Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувь ядуурлын түвшин өндөртэй хөдөө орон нутагт болон Хангайн ба Баруун бүсэд өндөр байна.

### **Монгол Улсын ядуурлын төрх байдал**

2012 оны байдлаар ядуурлын түвшин хөдөөд (35.3 хувь) хотыг (23.3 хувь) бодвол өндөр байгаа нь ядуурлын судалгаа явагдсан өмнөх онуудын үр дүнтэй адил байна. Гэхдээ хотжих үйл явц эрчимжиж байгаагаас хотод амьдарч буй ядуу иргэдийн тоо хөдөөнийхөөс илүү байна. Сумын төв

болон хөдөө нутагт ядуурлын түвшин 2010-2012 оны байдлаар огцом буурсан байна. Зудын хүчтэй сөрөг нөлөөтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл огцом буурсан, хамгийн сүүлийн зудын дараа эргэж сэргэхдээ харьцангуй бага өсөлттэй байсан нь хөдөөгийн иргэдийн хот руу олноороо нүүх үндсэн шалтгаан болсон. Ингэж нүүх гол зорилго нь тэдний хувьд амьжиргааны эх үүсвэр хайх явдал байсан. Түүнчлэн, хөдөө аж ахуйн 2011 оны тооллогын дүнгээс харахад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хөдөөгийн өрхийн 61 гаруй хувь нь тэдний үйлдвэрлэдэг бүтээгдэхүүний зах зээлийн үнэ хэт бага, 47 хувь нь бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлээс хэт алслагдсан гэжээ.<sup>3</sup>

Ядуурлын түвшин нь 40 хувиас дээш үзүүлэлттэй аймгуудын ихэнх нь Хангайн болон Баруун бүсэд байна. Өвөрхангай аймагт ядуурлын түвшин хамгийн өндөр (45.1 хувь), удаах байранд Говь-Алтай (44.0 хувь), Архангай (43.5 хувь), Хөвсгөл (43.1 хувь), Ховд (40.2 хувь) аймаг оржээ. Ядуурлын түвшин Өмнөговь (11.8 хувь), Дорноговь (16.9 хувь), Увс (17.7 хувь), Баян-Өлгий (19.7 хувь) аймагт болон Улаанбаатар хотод (19.7 хувь) хамгийн бага байна.

Аминдаа малтай байх нь хөдөөгийн өрхийн гол баялаг буюу хөрөнгө нь болдог. 2012 оны байдлаар нийт малчин өрхийн 30.8 хувийг 100-аас цөөн толгой малтай малчин өрх эзэлж байгаа хэдий ч эдгээр өрхөд нийт малын дөнгөж 6.2 хувь нь ногдож байна. Таван зуугаас дээш толгой малтай малчин өрхийг чинээлэг, харин 100-аас цөөн толгой малтай малчин өрхийг ядуу гэж ангилдаг.<sup>4</sup> Мал аж ахуй цаг агаарын байдлаас хэт хараат, ган, зуд болоход олон малчид малгүй болох нь хөдөөд ядуурлыг бий болгож байгаа үндсэн шалтгаан болох талаар чанарын судалгаанд оролцсон хөдөөгийн иргэд дурьдаж байлаа. Өөрийн гэсэн малаа зуданд алдсан хөдөөгийн ядуу өрхүүд амьжиргааны өөр амин зуулга хайх зорилгоор хот, суурин газар руу нүүж, хотын нийгэм, эдийн засгийн болон засаг захиргааны нэгжид ачаалал үүсгэж байна.

Найм буюу түүнээс дээш ам бүлтэй өрхийн 60 гаруй хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй, өрхийн тэргүүн нь боловсролгүй өрхийн 48 хувь нь ядуу байна. Өрхийн тэргүүн нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн 35 орчим хувь нь ядуу байна.<sup>5</sup> Өөрийн гэсэн орлогогүй хүүхдүүд өрхийн ядууралд хамгийн өртөмтгий гишүүдэд зүй ёсоор тооцогдож байна. Ядуурал дунд өссөн хүүхэд насанд хүрсэн хойноо ч гэсэн ядуу байх магадлал илүү болохыг харуулсан судалгаанууд байдаг.

### **Дүгнэлт**

Монгол Улсад хүнсний бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, хүнсний хомсдол, магадгүй газар хөдлөл зэрэг байгалийн гамшиг тохиолдох үед эдгээр үзэгдлүүд нь аж байдлын үзүүлэлтүүдэд шууд нөлөө үзүүлэх талтай. Иймээс эрсдэлийн үнэлгээ болон хяналтыг тасралтгүй хийж байх шаардлагатай.

2010 оноос өмнөх онуудын ядуурлын түвшинг өөр өөр аргачлалаар тооцсон нь ядуурлыг бууруулах бодлогыг төлөвлөхөд нөлөөлсөн хэдий ч үлдсэн хугацаанд бодлогын нэмэлт арга хэмжээ авсны үр дүнд 2015 он гэхэд ядуурлыг 18 хувьд хүртэл бууруулах зорилтод хүрэх боломжтой байна.

<sup>3</sup> ҮСХ, Тайлан “Хөдөө аж ахуйн тооллого 2011”, 2013

<sup>4</sup> Дэлхийн банк, Монгол Улс: Мал аж ахуйн салбарын судалгаа, Боть I – Нэгдсэн тайлан, 2008


<sup>5</sup> ҮСХ, Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгааны дүн, 2011

Эдийн засгийн хөгжлийн олон талт хэлбэр, иргэдийн амьжиргааны өөр өөр эх үүсвэрийг дэмжих, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх замаар хөдөө орон нутагт ажлын байр бий болгосноор ядуурлыг бууруулж, эмзэг болон өртөмтгий эдийн засгийг сайжруулах талтай.

Өнгөрсөн хугацаанд Засгийн газар нийгмийн халамжийн мөнгөн тусламж үзүүлэх нь ядуурлыг бууруулна гэж үзэж байсан. Гэвч, мөнгөн тусламж нь дангаараа ядуурлаас гарах тогтвортой арга зам биш гэдгийг олон улсын туршлага харуулж байна.

Ядуурлыг бууруулах нь удаан бөгөөд их хүч хөдөлмөр шаардсан ажил билээ. Энэ ажил нь бүх талуудын сонирхолд нийцсэн байж тэдний хамтын оролцооны үндсэн дээр хийгдэх ёстой байдаг. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн бодлогын хүрээнд ядуурлыг бууруулах стратегийг боловсруулж, ажлын байрыг олноор бий болгох асуудлыг онцолсноор ядуурал, тэгш бус байдлыг бууруулах шинэ боломж бүрдэх болно.

**Зорилт 2** Хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах




Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь 2000 онд 11.6 хувь байсан бол 2005 онд 5.3, 2010 онд 3.3 хувь болж буурсан байна. Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувийг бууруулах тал дээр хөдөө орон нутагт томоохон ахиц дэвшил гарсан. 2010 онд 6-аас доош сартай хүүхдүүдийн дунд энэ үзүүлэлт 2005 онтой харьцуулахад өссөн байна. Манай улс 2015 он гэхэд тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувийг 2.0 хувьд хүргэх зорилтыг хангах бүрэн боломжтой байна.

Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой (тухайн насандаа намхан) хүүхдийн эзлэх хувь 2000 онд 29.9 хувь байсан бол 2005 онд 27.5 хувь, 2010 онд 15.3 хувь болж буурсан. Тав хүртэлх насны хүүхдийн өсөлтийн хоцролтыг хот, хөдөө, хүүхдийн хүйс, баян, ядуугийн болон эхийн боловсролын түвшингөөр үнэлэхэд түүштай буурсаны зэрэгцээ ялгаа нь багассан байна. 2015 онд энэ үзүүлэлтийг 13 хувьд хүргэх зорилт бүрэн биелэх боломжтой.

Тав хүртэлх насны туранхай (өндөртөө зохицохгүй бага жинтэй) хүүхдийн эзлэх хувь 2000 онд 7.1 хувь байсан бол 2005 онд 2.7 хувь, 2010 онд 1.6 хувь болж буурчээ. Гэхдээ бүс нутгийн хувьд нэлээд ялгаатай байна. Тухайлбал, Баруун болон Зүүн бүсэд энэ үзүүлэлт улсын дунджаас өндөр байна. Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт мэдэгдэхүйц буурсан. 2015 онд зорилтдоо хүрэх бүрэн боломжтой.

**Зорилт 3** *Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах*



2015 онд ажиллах хүчний оролцооны түвшинг 70 хувьд, 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшинг 2.5 хувьд хүргэх зорилт тавьсан. Аргачлалын өөрчлөлтөөс шалтгаалж тоо мэдээг хооронд нь харьцуулах боломжгүй тул 1998-2008 болон 2009-2012 оны тоо мэдээллийг тус тусад нь авч үзэж, дүн шинжилгээ хийсэн болно.

Хүн амын ажил эрхлэлтийн түвшин 2009 онд 88.4 хувь байсан бол 2011 онд 92.3 хувь, 2012 онд 91.8 хувь болж өсчээ. Үндэсний үйлдвэрлэлд уул уурхай болон үйлчилгээний салбарын оролцоо нэмэгдсэн нь 2010-2012 онуудад хүн амын ажил эрхлэлтийн түвшин өсөхөд нөлөөлсөн байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин хөдөөд өндөр, Улаанбаатар хотод бага байгаа нь хөдөө орон нутгаас хотыг чиглэсэн хүн амын дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбоотой.

Ажилгүйдлийн түвшин 2009 онд 11.6 хувь байсан бол 2010 онд 9.9, 2011 онд 7.7 хувь болж тус тус буурчээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2011 онд баталж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг төрөл бүрийн хөтөлбөрүүдээр дамжуулан хэрэгжүүлсэн, мөн ажил олоход бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нэмэлт үйлчилгээнүүдийг бий болгосноор 2011 онд ажилгүйдлийн түвшин өмнөх онуудаасаа буурсан байна. Гэвч ажилгүйдлийн түвшин 2012 онд 8.2 хувь болж өссөн. 2009-2012 онуудад ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс ямагт өндөр байжээ.

Ажиллах хүчний судалгаагаар 2009 онд 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 22.0 хувь гарснаас хойш жил бүр аажим буурч, 2012 онд 14 хувьд хүрчээ. Залуучуудын ажилгүйдлийн түвшин ийнхүү буурсан нь Залуучуудыг ажил эрхлэлтэд бэлтгэх хөтөлбөр, Залуучууд, оюутнуудын ажил эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэнтэй холбоотой юм.

2012 оны байдлаар залуучуудын ажилгүйдлийн түвшин Зүүн бүс болон Улаанбаатар хот, мөн 11 аймагт улсын дунджаас өндөр байна. Залуучуудын ажилгүйдэл нь Дархан-Уул (30.9 хувь), Орхон (26.2 хувь), Хэнтий (21.6 хувь), Говьсүмбэр (19.8 хувь), Булган (19.3 хувь), Хөвсгөл (18.8 хувь) аймаг болон Улаанбаатар (17.1 хувь) хотод нэлээд тулгамдсан асуудал болж байна.

Аргачлалын зөрүүтэй асуудал байгаа ч, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилтыг 2015 он гэхэд хангахын тулд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

**Зорилт 4:** Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

Монгол Улсад хотжилт хурдацтай явагдаж байна. 2012 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 67.2 хувь нь буюу гурван хүний хоёр нь хотод амьдарч байна. 2000 оноос хойш хөдөө аж ахуйд тохиолдсон ган, зүд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл малчдад хүндээр түсч, ажлын байр хайх, амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор томоохон хот, суурин газар, ялангуяа Улаанбаатар хот руу шилжиж, хотжих үйл явцыг улам бүр нэмэгдүүлж байна.

Хүн амын шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн хөгжил болон бүс нутгийн хөгжлийн тэгш бүс байдлыг арилгахад эерэг нөлөө үзүүлдэг. Гэвч Монгол Улсын хувьд энэ нь сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод хүн ам олноор төвлөрч хөдөөгийн хүн ам огцом буурснаар хөдөөд нийгэм, соёлын үйлчилгээг хүргэхэд хүндрэлтэй болж байна. Мөн хөдөөгийн эдийн засгийн чадавхи буурч хот, хөдөөгийн ялгааг улам нэмэгдүүлж байна.

Монгол Улсын хотын хүн амын хурдан өсөлт нь шинээр шилжин ирэгсдийг суурьшуулах асуудлыг зохион байгуулах болон нийгмийн үйлчилгээнд хамруулах ажилд нэлээд хүндрэл бэрхшээл учруулж байна. Ялангуяа эмнэлэг, сургууль, зам, үндны усны хангамж, инженерын байгууламж бүхий орон сууц, нийгэм, соёлын бусад байгууламжаар хангах тал дээр хотын нийгэм, эдийн засгийн болон засаг захиргааны нэгжид ачаалал үүсгэж байна. Хүн амын хэт төвлөрөл, нийгмийн болон нийтийн үйлчилгээний хэт ачааллаас үүдэлтэй агаар, хөрсний бохирдол, хог хаягдал зэрэг нь хүн амын амьдралын тав тухтай амьдрах орчинд муугаар нөлөөлж, улмаар хүний хөгжлийг хангах боломжийг хязгаарлах хүчин зүйл болж байна.

Хот, суурин газарт хаягийн бүртгэлгүй оршин сууж буй иргэдийн талаар улсын хэмжээнд нэгдсэн статистик тоо мэдээ байхгүй тул хот, суурингийн нийт хүн амд хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын эзлэх хувь 2015 оны зорилтдоо хүрсэн эсэх талаар дүгнэлт хийх боломжгүй байна.

---

## ЗОРИЛГО 2 БҮХ НИЙТЭЭРЭЭ АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

---

Зорилт 5 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

Энэ зорилтын хэрэгжилтийг хэмжих гурван шалгуур үзүүлэлтийн чиг хандлага ойролцоо түвшинд байна. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, нэгдүгээр ангид элсэн ороод тавдугаар анги хүртэл суралцагчдын эзлэх хувь, 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь шилжилтийн дараах 1990-ээд оны үед буурч байсан боловч 2000 оноос өссөн байна.

Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин 1997-2012 оны хугацаанд Улаанбаатараас бусад бүх аймагт нэмэгдсэн байна. Бусад бүсүүдтэй харьцуулахад Баруун бүсэд хамгийн их ахиц гарчээ. Орхон аймгаас бусад бүх аймагт эмэгтэй хүүхдүүдийн бага сургуульд хамрагдалт эрэгтэй хүүхдүүдийнхээс илүү байна. Эрэгтэй хүүхдийг бага боловсролд хамран сургах талаар илүү анхаарах шаардлагатай байна.

Сургууль завсардалтын түвшин өндөр байгаагаас шалтгаалж Улаанбаатарт бага боловсролын хамран сургалтын цэвэр жин бусад аймгаас доогуур байна. Мүү сурлагатай суралцагчид дараагийн ангидаа дэвшин суралцаж чаддаггүй. Сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнх нь бага боловсролын эхний ангиудаас завсардах хандлагатай явж иржээ.

Монгол Улсын 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь хамгийн багатай Зүүн бүсэд анхаарлаа илүү хандуулах шаардлагатайг Хүн ам, орон сууцны сүүлийн 3 удаагийн тооллогын дүн харуулж байна. Гэвч 10 жилд нэг удаа хийдэг Хүн ам, орон сууцны тооллогоор уг мэдээллийг цуглуулдаг тул энэ үзүүлэлтийг тогтмол хянахад хүндрэлтэй юм.

Аймгуудаас ирүүлсэн тайлангаас үзэхэд хөдөөнөөс суурин газарт суурьших иргэдийн шилжих хөдөлгөөн нэмэгдсний улмаас сумдын сургуулийн хүүхдийн тоо цөөрч, сумдын сургууль хүчин чадлаараа бүрэн ажиллаж чадахгүйд хүрч байна. Мөн хүүхдийг байнгын оршин суугаа газраас нь өөр газарт сургуульд сургах явдал элбэг байгаа нь бүх хүүхдийг хамруулах, хамран сургалтын үзүүлэлтийг зөв тооцоход хүндрэл учруулж байна.


1990 оны шилжилт эхлэх үед Монгол Улсын бага боловсролын хамран сургалт, залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшин (97.5 болон 99 хувь) маш өндөр байсан бөгөөд, ийм өндөр суурь түвшингөөс бүх нийтээр суурь боловсрол эзэмшилтэд шилжихэд удаан хугацаа шаардагдаж болох юм. Гэвч бодлогын нэмэлт арга хэмжээ авсны үр дүнд 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох зорилтыг хангах боломжтой юм.

---

### **ЗОРИЛГО 3 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ**

---

*Зорилт 6 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах*




1995 оноос хойш Монгол Улсын боловсролын бүх түвшинд сургуульд хамрагдсан охидын тоо хөвгүүдээс үргэлж илүү байжээ. Гэхдээ сүүлийн 20 жилийн хугацаанд нэлээд өөрчлөлт гарчээ.

2000 онд бага боловсролын түвшинд охид, хөвгүүдийн тооны харьцаа бараг тэнцүү байсан боловч цаашид сургуульд хамрагдсан охидын тоо аажмаар буурчээ. 2012 онд бага боловсрол эзэмшиж байсан охид, хөвгүүдийн харьцаа 0.95 байв. Бага боловсролын түвшинд охид, хөвгүүдийн харьцааны зөрүү бүсээр болон хөдөө, хотод ялгаатай байна. Зүүн бүсийн хувьд 100 хөвгүүнд 94 охин ногдож байгаа бол Баруун болон Хангайн бүсийн суурин газарт охид, хөвгүүдийн харьцаа ойролцоо байна.

Ерөнхий болон дээд боловсролын түвшинд боловсрол эзэмшиж байгаа хөвгүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Ерөнхий болон дээд боловсролын түвшинд сургалтанд хамрагдсан охидын тоо хөвгүүдийнхээс давамгайлсан хэвээр байгаа боловч энэ харьцаа аажмаар буурч байна. Ерөнхий боловсрол бүрэн эзэмшилгүйгээр хөдөлмөр эрхлэхээр тэмүүлж байгаа хөвгүүдийн тоо нэмэгдсэн нь энэхүү тэнцвэр алдагдах шалтгаан болсон байж болзошгүй юм. Энэ зорилтыг 2015 он гэхэд хангахын тулд бодлогын нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байна.

*Зорилт 7 Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах*




2012 онд эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 69.0 хувь байхад эмэгтэйчүүдийнх 58.4 хувьтай байна. Энэхүү 11 нэгжийн ялгааг дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа эмэгтэй оюутны тоо харьцангуй их, хүүхэд асрах болон гэрийн ажил эрхэлж буй эмэгтэйчүүдийн тоо их, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд эрт өндөр насны тэтгэвэрт гардаг зэргээр тайлбарлаж болно. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь ерөнхийдөө буурсан байна. Энэ бүүралтанд 2008 оны эдийн засгийн хямрал хүчтэй нөлөөлсөн байна. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд Монгол Улсад эрэгтэйчүүд олноороо ажилладаг уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа нь уг үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийг аймаг, нийслэлээр авч үзэхэд нэлээд ялгаатай байна. Архангай, Увс, Баянхонгор аймгуудад эмэгтэйчүүд нийт ажиллагчдын тэн хагасаас илүү хувийг эзэлж байхад Өмнөговь аймагт дөнгөж 30.0 хувь, Дорноговь, Говьсүмбэр, Дархан-Уул, Сүхбаатар, Орхон аймгуудад эрэгтэйчүүд арай илүү байна.

Хөдөө аж ахуйн бус салбарын цалинтай ажил эрхлэлтэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилт 50 хувьд их дөхсөн бөгөөд 2015 он гэхэд биелэх боломжтой байна. Гэвч 2015 он гэхэд цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилтыг хангахын тулд нэмэлт арга хэмжээг авах шаардлагатай.

*Зорилт 8 Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх*



Дээд боловсролтой эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс их байдаг боловч улс төрийн, удирдлагын болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага байна. Үүний шалтгаан нь уламжлал, соёл, улс төрийн нөхцөл байдал зэргээс хамаарчээ.

Улс төрийн намаас эсвэл хараат бусаар УИХ-д сонгогдохоор өрсөлдсөн эмэгтэйчүүдийн харьцаа 1992 оноос хойш нэмэгдэж байна. УИХ-д сонгогдохоор санал болгосон эмэгтэйчүүдийн тоог 2015 он гэхэд 30 хувьд хүргэх зорилтыг 2012 оны УИХ-ын сонгуулиар хэрэгжүүлсэн байна. Гэхдээ УИХ-д сонгогдсон эмэгтэйчүүдийн харьцаа 2000 оноос хойш буурчээ. 2012 онд шинээр сонгогдсон УИХ-ын 76 гишүүний 11 нь эмэгтэй байсан нь нийт гишүүдийн 14.7 хувь болжээ. Энэ нь ихэнх Азийн орнуудын дундажтай харьцуулахад бага байна.

Эмэгтэйчүүдээс улс төрд оролцохыг хязгаарлаж буй хүчин зүйл нь сонгуулийн компани ажлын зардал их, хүйсийн талаарх хэвшмэл ойлголт, улс төрийн нөхцөл байдал зэрэг болно.



Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо нь 1990 оноос хойш буурсан. Төрийн захиргааны албаны хамгийн өндөр зэрэглэл болох тэргүүн түшмэлүүдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2003 оноос хойш буурчээ.

2011 оны 2 дугаар сард баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар төв, орон нутгийн төрийн үйлчилгээний удирдлагын түвшин дэх жендэрийн хязгаарыг тогтоосон. 2011 оны 12 дугаар сард баталсан УИХ-ын сонгуулийн тухай хуулиар УИХ-ын 76 гишүүнийг сонгох холимог тогтолцоог санал болгосон бөгөөд 48 гишүүнийг орон нутгийн сонгуулийн тойргоос, 28 гишүүнийг улс төрийн намын жагсаалтаас сонгох, үүний 20 нь эмэгтэй байхаар заажээ.


УИХ-ын гишүүдийн 30 хувийг эмэгтэйчүүд төлөөлөх гэсэн зорилтыг 2015 он гэхэд хангах магадлал бага байна.

---

## ЗОРИЛГО 4 ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

---

*Зорилт 9 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах*



Монгол Улсад 1,000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 97.2 байсан бол 2012 онд 18.9 болжээ. Нялхсын эндэгдлийн хувьд ихээхэн ахиц дэвшил гарч, 1990 онд 4,789 нялхас эндэж байсан бол 2012 онд 1,143 болж 76.1 хувиар бүүрчээ. Монгол Улс 2012 оны байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 4 дахин бууруулах зорилгыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Сүүлийн 22 жилийн хугацаанд мэдэгдэхүйц ахиц гарсан хэдий ч 2012 оны байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 11 аймагт, харин нялхсын эндэгдэл 9 аймагт улсын дунджаас өндөр байна. Энэ нь орон даяар эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Нэг хүртэлх насны хүүхдийн нас баралтын шалтгаанд эрт нярайн эндэгдэл, амьсгалын замын өвчин эхний байруудыг эзэлж байна. Хүүхдийн гэмтэл, орон нутаг дахь эмч мэргэжилтний хүрэлцээ хангалтгүй, үр чадварын түвшин муу, эцэг, эхийн хүүхэд асрах дадал, зуршил хангалтгүй, дэд бүтэц болон төвөөс алслагдсан байрлал зэрэг нь хөдөөд хүүхдийн эндэгдэл ихсэхэд нөлөөлөх үндсэн хүчин зүйл болж байна.

Нэг хүртэлх насны хүүхдийн улаанбурханы эсрэг дархлаажуулалтын хамралт тогтмол 90 хувиас дээш байгаа нь Монгол Улсын хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамралт сайн байгаагийн илрэл юм.


Монгол Улс 2012 оны байдлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 4 дахин бууруулах зорилгыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

---

## ЗОРИЛГО 5 ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

---

*Зорилт 10* Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах



1990-1997 оны хугацаанд эхийн эндэгдлийн түвшин 1993 онд хамгийн дээд түвшин буюу 100,000 амьд төрөлтөд 259-д хүрч, 1997 онд 143.5 болтлоо бүүрсан байна. 1997-2000 оны хооронд эхийн эндэгдлийн түвшин тогтвортой буурахгүй нэлээд хэлбэлзэлтэй байсан бол 2001-2006 онд эрчимтэй бүүрч, 2007-2010 онд хэлбэлзэлтэй байсан хэдий ч ерөнхийдөө буурах хандлагатай байжээ.


Монгол Улсад эхийн эндэгдлийн түвшин 1990-ээд онд нэлээд өндөр байсан бөгөөд эхийн эндэгдлийг бууруулах хоёр удаагийн стратегийг 2001-2010 онуудад хэрэгжүүлснээр 2001-2006 онд эхийн эндэгдэл эрчимтэй бүүрсан. Монгол Улсын Засгийн газраас Эхийн эндэгдлийг бууруулах стратегийн хамрах хүрээг өргөжүүлж, “Эх, хүүхдийн эрүүл мэндийн стратеги (2011-2015)”-ийг батлан, хэрэгжүүлж байна. Уг стратеги нь эхийн эндэгдлийг бууруулах зорилтыг 2015 он гэхэд хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэж байна.

Баруун болон Зүүн бүсэд эхийн эндэгдлийн түвшин 2012 онд улсын дунджаас их байна. Тухайлбал, 2012 онд найман аймагт эхийн эндэгдэл гараагүй бол, Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Сүхбаатар, Төв, Хэнтий аймагт энэ үзүүлэлт улсын дунджаас өндөр байна.

Монгол Улс 2015 оноос өмнө эхийн эндэгдлийг 100,000 амьд төрөлтөд 50 тохиолдол хүртэл бууруулах зорилтот түвшинд хүрэх боломжтой, харин эрүүл мэндийн ажилтан эх барьсан төрөлтийн хувийг 2015 оны зорилтот түвшинд хүргэж чадсан байна.

## ЗОРИЛГО 6 БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС (ХДХВ), ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ (ДОХ), СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 11 2015 он гэхэд ХДХВ, ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх



Монгол Улс ХДХВ-ийн тархалт багатай орон юм. 2012 оны эцсийн байдлаар Монгол Улсад ХДХВ-ийн халдвар насанд хүрэгчдийн дунд 0.1 хувиас бага тархсан бөгөөд ХДХВ-ийн халдвартай 127 хүн байна. ХДХВ-ийн нийт тохиолдлын 98 орчим хувь нь бэлгийн замаар дамжин халдвар (БЗДХ) авсан бөгөөд ХДХВ-ийн халдвартай нийт тохиолдлын 81 хувийг эрэгтэйчүүд эзэлж, тэдгээрийн дийлэнх нь эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд (ЭБЭ) байна. ХДХВ-ийн халдвартай нийт эмэгтэйчүүдийн тал орчим хувийг биеэ үнэлэгчид эзэлж байна.


Гэвч ХДХВ-ийн халдвартай тохиолдлын тоо, ялангуяа эрсдэлтэй бүлэг болох ЭБЭ-ийн дунд өссөөр байна. Түүнчлэн тэмбүүгийн тархалт эмэгтэй биеэ үнэлэгчид болон нийт хүн амын дунд өндөр байна. ХДХВ, ДОХ-той холбоотой ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлол түгээмэл хэвээр байна.

2012 оны байдлаар ХДХВ-ийн халдвартай хүмүүсийн дөрөвний гурав (75 хувь) нь 25-44 насныхан, тавны нэг нь 15-24 насныхан байна. ХДХВ-ийн халдвартай хүний тоо аймгуудад харилцан адилгүй байна. 2012 оны байдлаар ХДХВ-ийн халдвартай нийт хүмүүсийн 74 хувь нь Улаанбаатарт, 26 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Орон нутагт бүртгэгдсэн тохиолдлын ихэнх нь Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл, Сэлэнгэ, Увс аймгуудад гарсан байна.

Уул уурхай, дэд бүтцийн салбарт ажиллагчид болон бүтээн байгуулалт явагдаж буй бүс нутгийн хүн ам ХДХВ-ийн халдварт өртөх, дамжуулах эрсдэлтэйд тооцогддог боловч тэдгээрт зориулсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, зөвлөгөө, шинжилгээ, эмчилгээ тэр бүр хүртээмжтэй биш байна.

Монгол Улс жирэмсэн эмэгтэйчүүд болон 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ийн халдварын тархалтыг 0.1 хувиас бага түвшинд барих зорилтоо хэрэгжүүлж чадсан байна. Монгол Улсын Засгийн Газар нь “Гурван нэг”-ийн зарчмыг мөрдлөг болгон БЗДХ, ХДХВ, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, олон салбарын оролцоог нэмэгдүүлэх талаар онцгой анхааран ажилласан байна.

Зорилт 12 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах



Сүрьеэгийн тархалт болон өвчлөлийг бууруулах чиглэлээр томоохон ахиц дэвшил гарсан. Сүрьеэгийн тархалт 1990 онд 100,000 хүн амд 435 байсан бол 1997 он гэхэд 68 болж эрчимтэй буурсан. 1997 оноос хойш сүрьеэгийн тархалтыг зорилтот түвшин буюу 100,000 хүн амд 82-оос бага түвшинд барьж чадсан. Гэвч 2004-2006 онуудад энэхүү түвшингөөс ялимгүй их гарч байжээ. 2012 оныг 1990 онтой харьцуулахад сүрьеэгийн тархалт бүх аймагт буурсан байна.

Сүрьеэтэй өвчтөнгүүдийн 69 хувийг 16-44 насны хүмүүс, үүнээс 56 хувийг нь эрэгтэйчүүд, 44 хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна. Сүрьеэтэй өвчтөнгүүдийн тэн хагас нь ажилгүй, 70 хувь нь ядуу, нэн ядуу иргэд байна.

Сүрьеэгийн өвчлөлийн хамгийн өндөр түвшин буюу 100,000 хүн амд 186 тохиолдол 2006 онд бүртгэгдэж, үүнээс хойш өвчлөл буурсаар байгаад 2012 онд 100,000 хүн амд 139-д хүрсэн байна. Гэвч 1990 оноос хойших сүрьеэгийн өвчлөлийн чиг хандлагыг харахад өвчлөл өсөх хандлагатай байна. Сүрьеэгийн тархалт буурч, нааштай хандлагууд байгаа боловч өвчлөлийн түвшин аймгуудад харилцан адилгүй байна. Тухайлбал, 2012 оны байдлаар 19 аймагт өвчлөлийн түвшин 1990 онтой харьцуулахад нэмэгдэж, зөвхөн хоёр аймагт буурсан байна. Мөн оны байдлаар Дархан-Уул, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар аймаг болон Улаанбаатар хотод сүрьеэгийн өвчлөл улсын дунджаас өндөр байна.

Монгол Улсад хэрэгжүүлсэн Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд эмэнд мэдрэг болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (ОЭТС)-г оношлох, эмчлэх тал дээр томоохон ахиц дэвшил гарч байна. Гэсэн хэдий ч сүрьеэгийн өвчлөл өсч байгаа нь сүрьеэг эрт илрүүлэх, эмчлэх, хянах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Түүнчлэн сүрьеэгийн өвчлөл дорвитой буурахгүй байгаад сүрьеэгээр өвдөгсдийн өвчин нь дахин сэдрэх, өвчилсөн тохиолдолд эмчид үзүүлэхгүй байсаар хожуу оношлогдох, оношлогдох хүртлээ халдвараа бусдад тараах, эмчлэгдэж байгаа тохиолдолд эмчилгээгээ орхих, таслах, эмэнд тэсвэртэй сүрьеэтэй болох зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.

2015 он гэхэд сүрьеэгийн тархалтыг 100,000 хүн амд 82-т хүргэх зорилтыг бүрэн хэрэгжүүлсэн, харин нэмэлт арга хэмжээ авснаар сүрьеэгийн өвчлөлийг 100,000 хүн амд 100-д хүргэх зорилт хэрэгжих боломжтой байна. Түүнчлэн оношилгоо, эмчилгээний олон улсын стандарт (ДОТС)-ын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувийг 2015 он гэхэд 100-д хүргэх зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй байдал харагдаж байна.

ОЭТС-тэй өвчтөний эмчилгээгээ таслах, үр дүнгүй болох тохиолдол нэмэгдэж байгаа нь аймаг, сумын түвшингийн ОЭТС-ийн эмчилгээний хяналт сул, сүрьеэгийн байгууллагын боловсон хүчний хангамж, тогтвор суурьшил муу байгаагаас голлон шалтгаалж байна. Иймээс өрхийн эмч нарыг чадавхижуулах чиглэлээр сургалт зохион байгуулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх шаардлагатай байна.

1 ба 2 дугаар эгнээний эм болон гаж нөлөөний эмийн хангалт буурч байна. Сүрьеэгийн 1 дүгээр эгнээний эмүүд болон 5 дугаар бүлгийн эмүүдийн хангамжийг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай байна. Үүнээс гадна шийдвэр гаргагчид сүрьеэ өвчний талаарх мэдээллээр бүрэн хангагдахгүй байгаа тул сүрьеэгийн өвчлөлийг бууруулах талаар авах бодлогын шийдвэрт зохих хэмжээгээр нөлөөлж байна.

*Зорилт 13 Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах*

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн


5-6 насны хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын үзүүлэлтийг тооцох тоон мэдээлэл хомс байгаагаас 2015 онд зорилтот түвшин буюу 75 хувьд хүрсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна.

---

## ЗОРИЛГО 7 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

---

*Зорилт 14 Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот, суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх*



Монгол Улс үүр амьсгалын өөрчлөлттэй хэдийн нүүр тулаад байна. Сүүлийн 100 жилд агаарын дундаж температур дэлхийн хэмжээгээр 0.7 хэм дулаарсан бол Монгол орны агаарын жилийн дундаж температур 1940 оноос 2007 оны хооронд 2.1 хэмээр дулаарсан байна.

Монгол Улс дэлхийн бусад улс орнуудын адилаар үүр амьсгалын дулааралд нэрвэгдэж байна. Монгол Улсын эдийн засаг, хүн амын амьжиргаа, уламжлалт нүүдлийн соёлд үүр амьсгалын ирээдүйн өөрчлөлт ихээхэн нөлөөлөхөөр байна.

Цөлжилт нийт нутаг дэвсгэрийн 70 хувийг хамарч, олон гол горхи, нүүр цөөрөм, булаг шанд ширгэж байна. Бэлчээрийн өвс ургамал доройтож, эдийн засгийн гол салбар болсон бэлчээрийн мал аж ахуйг эрхлэхэд хүндрэл учруулж, хөдөөгийн малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлөх болсон. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад үүл уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг улам хурцаар тавих шаардлагыг бий болгож байна.

### **Ойт нутгийн эзлэх хувь**

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ)-ны мэдээллийн эх үүсвэрээр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 12.5 сая га буюу 8 хувь нь ойгоор бүрхэгдсэн талбай байна.

2015 он гэхэд ойт нутгийн эзлэх хэмжээг 9 хувьд хүргэх энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд одоо байгаа ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 1.6 сая.га-гаар нэмэгдүүлэх шаардлагатай. Ийм хэмжээний талбайг ойжуулахад манай орны байгаль цаг агаарын онцлог, ойн сангийн өнөөгийн нөхцөл байдал, улсын санхүүжилтийн бэрхшээл, цаг хугацаанаас шалтгаалан үлдсэн хугацаанд зорилтот хэмжээнд хүргэх боломжгүй байна.

### **Тусгай хамгаалалтанд авсан газар нутаг**

Монгол Улсын төрөөс улс орныхоо экологийн тогтвортой байдлыг хангах, биологийн олон янз байдлын хомсдлыг бүүруулах, байгалийн жамаар нөхөн сэргэх нөхцөлийг бүрдүүлэх, байгаль, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газруудын хэв шинжийг хадгалах, хувьсан өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх арга хэмжээг тасралтгүй авсаар ирлээ.

Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь 1990 онд 3.6 хувь байснаа 2000 он хүртэл 13.1 хувьд хүрч нэмэгдэж ирсэн боловч түүнээс хойших 10 гаруй жилд төдийлөн ихээр өсөөгүй байна. БОНХЯ-ны мэдээллийн эх үүсвэрээр 2012 онд 1.3 сая.га талбай бүхий 15 газрыг УИХ-ын шийдвэрээр улсын тусгай хамгаалалтад шинээр хамруулснаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт нутгийн 17.4 хувийг эзлэх болсон байна. Нийт газар нутгийн 10.3 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна. Хэрэв Засгийн газар улсын болон орон нутгийн хамгаалалтанд авах газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж чадвал 2015 он гэхэд тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн эзлэх хувийг 30-д хүргэх зорилт биелэгдэх боломжтой байна.

1994 онд УИХ-аас Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1997 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1998 онд Тусгай хамгаалалттай газар нутгийн Үндэсний хөтөлбөрийг тус тус баталсан нь тусгай хамгаалалттай газар нутгийг байгуулах, менежментийг хөгжүүлэх зэрэг харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

### ***Агаарын бохирдол***

Сүүлийн 3 жилд Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн болон хүхэрлэг хийн агууламж хурдацтай нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд зөвхөн Улаанбаатар хот төдийгүй аймгийн төвүүд, зарим томоохон суурин газрын агаарын бохирдол нэмэгдэж анхаарал татах түвшинд хүрээд байна.

Өнгөрсөн хугацаанд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар олон арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Гэр хорооллыг барилгажуулахад шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх, орон нутгийн агаарын бохирдлыг бууруулах, “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс”-д оршдог айл өрхийг эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнээр хангах, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор урамшуулал олгох, холбогдох журам, стандартыг боловсруулан батлан мөрдүүлж, агаарын чанарын мэдээг олон нийтэд хүргэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.

Дээр дурьдсан бүсийн айл өрхүүдэд Монголын Мянганы сорилтын сан болон Цэвэр агаар сангаас 120.0 мянган сайжруулсан зуух, 21.0 мянган гэрийн дулаалга, 5.1 мянган гонх, 15.0 мянган тонн боловсруулсан түлш, 1.5 мянган дулаан баригч, нэг мянган яндангийн шүүлтүүр болон бусад эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүнийг хөнгөлттэй үнээр болон үнэ төлбөргүй олгожээ. Тухайлбал, сайжруулсан зуух худалдан авсан өрхүүдэд 80-90 хувь, боловсруулсан түлш худалдан авсан 7.5 мянган өрхөд үнийн дүнгийн 40 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлтийг үзүүлжээ.

2012 оны байдлаар Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж 2015 онд хүрсэн байх түвшингөөс даруй 2.6 дахин өндөр, харин хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж хүрсэн байх түвшингөөс 3.1 дахин өндөр байгаа нь хот, суурин газарт, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэхээр дэвшүүлсэн зорилт хэрэгжих боломжгүйг харуулж байна.

Нүүрсхүчлийн хийн ялгаралтыг 2015 он хүртэл 4 тонн/хүн-д хүргэх зорилт тавьсан байдаг ч энэ зорилт биелэгдэх боломжгүй юм. Учир нь Монгол Улсын эдийн засаг тэлж, хүн ам өсч, үйлдвэрлэл хөгжихийн хэрээр хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй өөрөөр хэлбэл, түлшний шаталтаас үүсэх хүлэмжийн хийн ялгаралт даган өсөх хандлагатай байна. Гэсэн хэдий ч хүлэмжийн хийн



ялгаралтыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээний дүнд нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ногдох хүлэмжийн хийн ялгаралтыг сааруулах боломжтой юм.

Монгол Улс нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенци болон түүний Киотогийн протокол, түүний нэмэлтэд 1993, 1999 онуудад тус тус нэгдэн орсон бөгөөд конвенци болон протоколын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах чиглэлээр Киотогийн протоколын Цэвэр хөгжлийн механизмыг 2004 оноос хойш хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлийн нийт таван төсөл, хөтөлбөр хэрэгжиж, уг механизмын хүрээнд одоогоор нийт 76,950 тонн нүүрсхүчлийн хийтэй тэнцүү хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулснаа баталгаажуулаад байна.

*Зорилт 15      Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах*

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

2011 онд 181 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан тохижуулсан бол 2012 онд 288-ыг нэмж хамгаалсан бөгөөд сүүлийн 3 жилд нийтдээ 856 булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан тохижуулсан байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын нөлөөгөөр сүүлийн жилүүдэд мөнх цэвдэг хурдацтай хайлах, гол, мөрний эх ширгэх, урсац багасах, тасрах, рашааны ундарга багасах, ширгэх зэргээр сөрөг үзэгдлүүд улам бүр нэмэгдэх боллоо.

БОНХЯ-ны мэдээллийн эх үүсвэрээр хамгаалалтанд авсан гол мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувийг 2015 он гэхэд 80.0-д хүргэх зорилт хараахан биелэгдээгүй, харин хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандны эхийн тоог (өсөн нэмэгдэх дүнгээр) 2015 он гэхэд 1,000-д хүргэх зорилт 2012 оны байдлаар бүрэн хэрэгжсэн байна.

*Зорилт 16      2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах*

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн


Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувийг бууруулахад ахиц дэвшил гарч, түүнийг 2015 он гэхэд 40.0 хувь хүртэл бууруулахаар дэвшүүлсэн зорилт давж биелэгдэн, 2010 онд 27.4

хувьд хүртэл бүүрчээ. Гэхдээ аймгуудын хэмжээнд ихээхэн ялгаатай байна. Баян-Өлгий аймагт хүн амын 86.5 хувь нь баталгаат үндны усаар хангагдаагүй нөхцөлд амьдарч байхад энэ үзүүлэлт Улаанбаатарт ердөө 3.4 хувь байна.

Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг улсын хэмжээнд 2015 онд 60-д хүргэж бүүруулах зорилтын хэрэгжилт удаашралтай, харин Хангайн бүс, Улаанбаатар хотод ийм хүн амын эзлэх хувь нэлээд хэмжээгээр нэмэгджээ.

Энэ үзүүлэлт нэмэгдсэн нь хөдөөнөөс шинээр шилжин ирэгсэд нэмэгдэж, тэд гэр хороололд голлон амьдарч, богино хугацаанд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоогүйтэй холбоотой байна. Үлдсэн хугацаанд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа орон сууцны хөтөлбөрийг эрчимжүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авсан тохиолдолд сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бүүруулж, тавьсан зорилтод хүрэх боломж байна.

*Зорилт 17 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах*



2010 оны Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс харахад инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг 2015 он гэхэд 30-д хүргэхээр дэвшүүлсэн зорилтийн хэрэгжилт хангалтгүй байгаа боловч, ойрын жилүүдэд эрчимтэй хэрэгжүүлэх орон сууцны хөтөлбөрүүдийн үр дүнд энэ зорилт биелэгдэх боломжтой.

Инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь 2010 оны байдлаар хотод 30.5 хувьд хүрсэн бол хөдөөд 14.0 хувь байна. Баруун болон Хангайн бүсийн Завхан, Говь-Алтай, Хөвсгөл, Архангай, Булган, Өвөрхангай, Баян-Өлгий аймагт инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь бусад аймагтай харьцуулахад бага байна.


“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Засгийн газрын 2012-2016 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 135 дугаар тогтоолыг баталсан. Засгийн газраас Төрийн орон сууцны корпораци гэсэн төрийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулах шийдвэр гаргасан. Ерөнхий сайдын шүүд харъяанд ажиллах энэ байгууллага нь төрийн албан хаагч, залуу гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг зорилтот бүлгийг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлэх, түрээсийн байр олноор барьж, иргэдэд хямд үнэ, боломжийн нөхцөл санал болгох ажлыг хариуцан ажиллах юм.

---

## ЗОРИЛГО 8 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

---

*Зорилт 18 Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх*



Монгол Улс 2010 онд 126 оронтой худалдаа хийж байсан бол 2012 онд нэмэгдэж 146 оронтой худалдаа хийх болжээ. Экспортын хэмжээ 4.4 тэрбум ам.долларт хүрсэн нь ДНБ-ий 51 хувьтай тэнцэж, 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтод хүрэх боломжтой байна.


Сүүлийн жилүүдэд Монгол Улсын экспортын хэмжээ ихээхэн өссөөр ирсэн. 2012 оны экспортын хэмжээ 2005 оныхоос 4.1 дахин нэмэгдсэн нь нүүрс, зэс, төмрийн хүдэр, газрын түүхий тосны экспорт эрс нэмэгдсэнтэй холбоотой. Хэдийгээр Монгол Улсын экспортын хэмжээ өссөөр байгаа боловч экспортын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байна.

Монгол Улс 2012 оны байдлаар 139 орноос гарал үүсэлтэй 6.7 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээ импортлосон байна. Эрдэс бүтээгдэхүүний импортын 88 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. Монгол Улсын худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн эзлэх хувь 2012 онд өмнөх онуудтай харьцуулбал хамгийн өндөр хэмжээнд буюу ДНБ-ий 0.13 хувийг эзэлж байна.

ХАЁТ-ийн эзлэх хувийг 2015 онд 10.0 хувьд хүргэх зорилт биелэхээргүй байна. Харин нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн ХАЁТ-ийн эзлэх хувь 2012 онд 26.3 хувь болж, дэвшүүлсэн зорилтоос давж биелжээ.

Монгол Улсад 13 банк үйл ажиллагаа явуулж байна. Санхүүгийн салбар ерөнхийдөө арилжааны банкуудаас бүрдэж байгаа нь ихэнх хөгжиж буй орнуудад байдаг түгээмэл үзэгдэл юм. Сүүлийн жилүүдэд Монголын хөрөнгийн биржэд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэж, зах зээлийн нийт үнэлгээ нэмэгдсэн. Гэвч хоёрдогч зах зээлийн хэмжээ бага тул нөлөө бага байна.

*Зорилт 19 Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх*



Монгол Улсын нийт ачаа тээврийн 90 орчим хувийг төмөр замын тээвэр эзэлж байна. Сүүлийн жилүүдэд төмөр замын тээврээр гадаадад дамжин өнгөрсөн ачааны хэмжээ тасралтгүй бүүрч 2010 онд 13.8 хувь болжээ.

НҮБ-ын Худалдаа, тээврийг хөнгөвчлөх хорооны дэмжлэгтэйгээр Оросын Холбооны Улс (ОХУ), Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын нутгаар дамжин өнгөрөх тээврийн хэлэлцээрийг байгуулах ажлыг 10 гаруй жилийн өмнөөс эхэлсэн боловч тодорхой үр дүнд хүрч чадаагүй байна. Энэ хэлэлцээрийг байгуулж чадвал далайд гарцгүй Монгол Улс тээврийн тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой болно.

Бараа, бүтээгдэхүүн экспортлохын тулд Монгол Улс тээврийн өндөр зардал, тариф төлдөг. Зүүн Ази, Европын орнууд руу бараа тээвэрлэхийн тулд ОХУ-ын нутаг дэвсгэрээр 4,000 км дамжин өнгөрч, Зүүн Өмнөд Ази болон бусад орнууд руу тээвэрлэх бараа БНХАУ-ын Тяньжины боомтоор дамжихад 1,700 км зам туулдаг байна.

Засгийн газрын 2012-2016 оны Үйл ажиллагааны хөтөлбөрт улсын хилийн шалган нэвтрүүлэх цэгийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах, хилийн боомтын удирдлагын асуудлыг тэргүүлэх чиглэл гэж үзсэн. Хилийн боомт дээр үйл ажиллагаа явуулж буй үндэсний байгууллагууд (хилийн цэрэг, цагдаа, гааль, мэргэжлийн хяналт)-ын бүтцэд шинэчлэлт хийн, хилийн дамжин өнгөрөх гол цэгүүдийн дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх нь эдийн засгийн салбаруудыг төрөлжүүлэн хөгжүүлэх төдийгүй хил дагуу байрлах орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих болно. Үүний гол зорилго нь худалдаа, тээврийг дэмжих замаар Монгол Улсыг “далайд гарцгүй” биш “газраар гарцтай” орон болгоход чиглэх юм.

Засгийн газар хилийн боомтын удирдлагыг сайжруулах, гадаад худалдааг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Энэ хуулийн нэг зорилго нь нэг цонхны үйлчилгээ үзүүлэх шинэ бүтцийг байгуулж шат дамжлагыг багасгахад чиглэж байна. Хуулийн төслийг одоо УИХ-аар хэлэлцүүлж байна.

Монгол Улс нь Төв Азийн Бүсийн Эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр, Их Түмэн Санаачилга зэрэг бүсийн санаачилгуудын гишүүн юм. Гол анхаарлаа хандуулах зүйл нь худалдааг хялбарчлах, хилээр дамжин өнгөрөх худалдааны урсгалыг шүүрхай, үр ашигтай байлгахын тулд хилийн боомтын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

Монгол Улсын Засгийн газар хилийн шалган нэвтрүүлэх цэгийн бодлогыг хөгжүүлж, Монгол Улсын далайд гарцгүй статусаас хамааран худалдаанд үүсдэг хязгаарлалтыг багасгахад туслах хилийн нэгдсэн удирдлагын үндэсний чадавхийг сайжруулахыг зорьж байна.

*Зорилт 20 Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх*

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

2012 оны байдлаар ДНБ-д Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь 32.0 (1.5 тэрбум ам.долларын бонд орсон) болж, 2015 онд 30.0 хувь байх зорилтоос давсан байна. Гэвч сэрэмжлүүлэх түвшингөөс (40.0 хувь) бага байгаа бөгөөд Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас тогтоодог өрийн тогтвортой байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд “гадаад өрийн эрсдэл багатай орон” гэсэн ангилалд багтаж байна.

Засгийн газрын үнэт цаасны арилжаа явуулах цахим арилжааны системийг нэвтрүүлсэн нь хөрөнгө оруулагчдад арилжааны талаарх мэдээллийг шуурхай авах боломж бий болгосон.

*Зорилт 21 Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах*

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

Монгол Улсад мэдээлэл, холбооны технологийн салбар маш түргэн хөгжиж, шинэ технологи хурдацтай нэвтэрч байгаагийн тодорхой жишээ бол интернет болон үүрэн телефон хэрэглэгчдийн тоо өндөр хурдтай өсч ирсэн явдал юм. 1,000 хүнд ногдох интернет хэрэглэгчдийн тоо 2009 онд зорьсон түвшиндээ хүрсэн бөгөөд интернет хэрэглэгчдийн тоо 2012 онд 700 мянгад хүрсэн байна. Энэ тоо улам нэмэгдэх хандлагатай байна. Үүрэн холбооны хэрэглэгчид жил бүр өсөн нэмэгдсээр нийт 2.8 сая хүн амтай харьцуулахад давхардсан тоогоор 3.4 сая хэрэглэгчтэй болсон байна. Сүлжээ, үйлчилгээний хүрээ нь нутаг дэвсгэрийн 90.0 хувийг хамардаг боллоо.

Олон улсад “гурвалсан үйлчилгээ” дэлгэрч, Монголд 2011 онд интернет протоколд суурилсан багц үйлчилгээ нэвтэрч эхэлсэн. Энэ багц үйлчилгээний хүрээнд интернет протоколтой суурин утасны хэрэглэгчид шинээр бий болж 14.0 мянган хэрэглэгч бүртгэгдэж байсан бол 2012 онд 27.7 мянга болж бараг 2 дахин өссөн байна.


Энэхүү технологийн асар хурдтай нэвтрэлтээс хамаарч Монгол Улсын интернет болон үүрэн телефон хэрэглэгчдийн тоог өсгөх талаар дэвшүүлсэн зорилт төлөвлөсөн хугацаанаас эрт биелсэн бөгөөд мэдээлэлжсэн нийгэм байгуулахад их хувь нэмэр оруулж байна.

---

## ЗОРИЛГО 9 ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

---

**ЗОРИЛТ 22** *Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох*



Дүгнэх  
боломжгүй

Биелэх  
боломжгүй

Нэмэлт арга  
хэмжээ авснаар  
хэрэгжих  
боломжтой

Биелэх  
боломжтой

Бүрэн  
биелсэн

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа шинэчлэн баталснаас хойш Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар зэрэг шинэ, бие даасан байгууллагуудыг байгуулсан. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох, өөрчлөлт, шинэчлэлийг хийхэд ихээхэн анхаарч байна.

НҮБ-ын Хүний хөгжлийн Илтгэл (2013)-д дурдсанаар Монгол Улс хүний хөгжлийн 0.675 индексээр дэлхийн 175 орноос 108 дугаар байранд оржээ. Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын хүний хөгжлийн дундаж индекс 2012 оны байдлаар манай орныхоос арай дээгүүр 0.683 байна. 2015 он гэхэд Монгол Улсын хүний хөгжлийн индексийг 0.830-д хүргэх зорилтот түвшинд хүрэх боломжтой байна. Гэвч, ерөнхий индексийг хойш татаж буй хоёр үзүүлэлт нь нэг хүнд ногдох орлого болон дундаж наслалт юм.

### **Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж буй талаарх шинжээчдийн үнэлгээ**

Монгол Улс НҮБ-ын хүний эрхийн талаарх олон улсын 9 суурь конвенцийн долоог соёрхон баталж, нэгд нь гарын үсэг зураад байна. 2008 онд Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцид нийцэж байгаа талаарх үнэлгээ 3.4 хувь байсан бол 2011 онд 3.9 болж ахиц гарсан. Энэ үнэлгээнд одоогоор өөрчлөлт ороогүй байна.

Монгол Улсад хүний эрх зөрчигдсөн олон тохиолдол байна. Хүүхдүүдийн 43 хувь нь гэр бүлдээ, 52 хувь нь сургууль дээрээ, 5 хувь нь олон нийтийн газарт хүчирхийлэлд өртөж байгааг судалгааны дүн харуулж байна. Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт хангалтгүй байна гэж Хүний эрхийн үндэсний комисс үзэж байна. Хурдан морь унаач хүүхдийн эрх, аюулгүй байдал хөндөгдсөөр байна. Бэлгийн цөөнх буюу лесбиан, гей, бисексуал, трансжендэр хүмүүсийн төрөлхийн байдлыг нь хүлээн зөвшөөрдөггүйгээс нийгмийн бүхий л салбарт ялгаварлан гадуурхдаг. Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчин доройтох, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны

бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах, газар эзэмших, өмчлөх, аж ахуй эрхлэх эрх ноцтой зөрчигдөх болсон.<sup>6</sup>

### **Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт**

Шүүхийн шийдвэрийг түргэн шуурхай, бүрэн гүйцэд биелүүлж, хохирлыг буруутай этгээдээс гаргуулж, төлбөр авагчид олгох нь зөрчигдсөн эрхийг сэргээх чухал баталгаа юм. Гэтэл энэ асуудал хохирогчийн хувьд удаан хугацаанд хүлээлгэх, тэр бүр бүрэн гүйцэд хэрэгжихгүй байх явдал гарсаар байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь 2010 онд 52 хувь байсантай харьцуулбал сүүлийн 2 жилд ихээхэн дээшилж, ахиц гарчээ. Гэвч шүүхээс гаргасан дөрвөн шийдвэр тутмаас нэг нь хэрэгжихгүй байгаагаас иргэдийн эрх хохирсоор байна.

### **Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо**

Монгол Улсад эрүүгийн хэрэгт холбогдон ял эдэлж буй хүмүүсийн 80 орчим хувь нь ядуу, ажилгүй хүмүүс байна. Тиймээс төлбөрийн чадваргүй иргэдэд эрүүгийн хэргийн бүх шатанд хууль зүйн туслалцаа үзүүлэх нь хүний эрх зөрчигдөх явдлыг арилгах, эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй. Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо 2007-2009 оны хооронд буурч, харин сүүлийн 3 жилд харьцангуй тогтвортой байгаа боловч 2004 оны түвшинд хүрээгүй байна.

Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх, харъяа нутаг дэвсгэрийнхээ иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах чиг үүрэгтэй Эрх зүйн туслалцааны төвүүдийг бүх аймаг, дүүрэгт ажиллуулах бүтцийг бий болгосон. Төвүүдийг НҮБ-ын дэмжлэгтэй хэрэгжиж буй Эрх зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх төслийн хүрээнд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэд байгуулсан байна. Энэ үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс 2012 онд нийт 240.0 сая төгрөгийг зарцуулжээ. 2013 онд УИХ-аас Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг баталсан байна.

### **Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл**

2012 оны судалгааны дүнгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгааны дэд түүвэрлэлтэнд хамрагдсан, насанд хүрсэн нийт 3,744 иргэний 12.6 хувь нь санал нийлдэг гэж хариулсан байна. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь эдийн засаг, санхүүгээс нэлээд хараат байна гэж үзжээ. Иргэд энэ асуудалд улам шүүмжлэлтэй хандах болсныг харууллаа.

### **Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байршуулдаг төрийн байгууллагын тоо**

Сүүлийн 3 жилд төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байршуулдаг төрийн байгууллагын тоо тасралтгүй нэмэгджээ. 2011 оны эцсийн байдлаар төрийн өмчит компаниудыг оролцуулахгүйгээр төсвөөс санхүүждэг 4 мянга орчим байгууллага байснаас дөнгөж 8.7 хувь нь төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байршуулж байв. Сангийн яам

<sup>6</sup> ХЭҮК, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь Илтгэл”, 2013



“Төсвийн ил тод байдал” гэсэн вэб хуудас ажиллуулж, улсын нэгдсэн төсвийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэж байна. Вэб хуудсан дахь төсвийн талаарх мэдээлэл иргэдэд хэр ойлгомжтой хэлбэрээр тавигдсан, ашиглахад хялбар эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

**ЗОРИЛТ 23** Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

Сүүлийн хоёр жилийн хугацаанд ардчиллын үндсэн зарчмыг бэхжүүлэх, түүний дотор сонгуулийн тогтолцоог боловсронгуй болгох, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн албаны шударга байдлыг дээшлүүлэх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарчээ.

УИХ-ын Сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн 2011 онд батлагдаж, сонгуулийн олонхийн (шууд) тогтолцооноос холимог тогтолцоонд<sup>7</sup> шилжин, улс төрийн намуудаас нэр дэвшигчдийн 20 хувь нь эмэгтэйчүүд байх доод хязгаарыг хуульчилсан байна. 2012 оны УИХ-ын сонгууль, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах ажиллагаанд иргэд чөлөөтэй оролцох бололцоог олгох хэд хэдэн шинэчлэл хийгдэв. Эдгээр арга хэмжээ нь сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой зөрчлийг арилгах, сонгууль шударга, шуурхай явагдах, сонгогчийн эрхийг хангахад ач холбогдолтой болсон. Гэвч УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн аль алинд ирц буурсан байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжихийн тулд Төсвийн тухай шинэ хуулиар хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, түүний дараа хуваарилсан орон нутгийн төсөвт оролцох иргэдийн оролцоог дэмжих “Орон нутгийн хөгжлийн сан” бий болсон. 2013 оноос эхлэн хөрөнгө оруулалтын саналыг орон нутгийн иргэдээр хэлэлцүүлж, хэрэгжүүлэх эрхийг орон нутгийн удирдлагад өгсөн байна. Орон нутгийн иргэд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих боломжтой болсон байна.

Иргэдэд үйлчилгээг хүнд сурталгүй, хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Төрийн үйлчилгээний цахим машин” буюу “Түц Машин”-ыг 2013 оноос суурилүүлж эхлэв. Төрийн бодлого, шийдвэр, үйлчилгээний талаар иргэдийн санал гомдлыг авах 11-11 дугаартай утсыг ажиллуулж байна. Ерөнхийлөгч Иргэдийн Танхимыг санаачилан байгуулсан байна.

<sup>7</sup> УИХ-ын 76 сүүдлын 48-ыг мажоритор тогтолцоогоор, 28 сүүдлыг хувь тэнцүүлсэн тогтолцоогоор сонгоно.

Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн

Монгол Улсын Авлигын индекс 2011 онд 0.63 болж, 2009 оныхоос 0.01 пунктээр буурсан байна. Өөрөөр хэлбэл, 2011 оны байдлаар авлигын нөхцөл байдал дордсон гэсэн үг юм. Авлигын индексийг бүрдүүлэгч үзүүлэлтүүдээс “авлигын хэлбэр”-ийн үзүүлэлт 0.02 пунктээр буурсан нь авлигын индекс ийнхүү буурахад нөлөөлж, авлига хэлбэр талаасаа илүү ноцтой байдлаар илрэн гарах болсныг харуулж байна. Улс төрийн томилгоо, улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлийн ашиг сонирхол, намын болон сонгуулийн санхүүжилтийн механизм зэрэг нь энэ байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс юм.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд авлигатай тэмцэх, төрийн албан дахь хүнд суртал, шударга бус байдлыг бууруулах, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, ашиг сонирхлын зөрчлийг арилгах чиглэлээр томоохон шинэчлэлийг хийв. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд хүлээн авч бүртгэх тогтолцоонд бүрэн шилжээд байна. 2012 оноос эхлэн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн эдгээдийн ашиг сонирхлыг холбогдох байгууллага хянадаг болсон.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013)-ийг шинээр, Эрүүгийн хууль (2011, 2012)-ийг шинэчлэн баталсан байна. Эдгээр шинэчлэлүүд нь авлигатай шийдвэртэй тэмцэл өрнүүлэхэд том хувь нэмэр оруулсан байна.

Улс төрөөс ангид, төвийг сахисан, чадварлаг төрийн албыг бүрдүүлэх зорилт олон шалтгааны улмаас биелэхгүй байна. Сонгууль бүрийн дараа төрийн албан хаагчдын томоохон халаа солио хийгдэж, ялалт байгуулсан намыг дэмжигчид, өөрийн талын хүмүүсийг захиргааны албан тушаалд томилж байгаа нь Засгийн газрыг бүрдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна. Харамсалтай нь энэ байдал УИХ-ын 2012 оны сонгуулийн дараа давтагдсан юм.

Ардчиллын талаарх ойлголтыг бэхжүүлэх, авлигыг үл тэвчих үзэл, эрх зүйг төлөвшүүлэх, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр залуучуудад зориулсан хөтөлбөр боловсруулах, авлигын хор хөнөөлийг ойлгуулах хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах ажлыг эхлүүлжээ.

---

## ХЭРЭГЖЭЭГҮЙ МХЗ-УУД: 2015 ОНООС ХОЙШ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

---

Мянганы Тунхаглалыг 13 жилийн өмнө баталснаас хойш Монгол Улс анхаарал татахуйц олон үр дүнд хүрсэнийг тэмдэглүүштэй. Тухайлбал, (1) үндэсний түвшинд МХЗ-уудын талаарх өөрийн гэсэн ойлголтыг бий болгож чадсан, (2) МХЗ-уудын зорилт, шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн онцлогт нийцүүлсэн, (3) Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх есдүгээр зорилгыг нэмж тодорхойлсон, (4) МХЗ-тод суурилсан Үндэсний Хөгжлийн Цогц Бодлогыг боловсруулсан, (5) МХЗ-уудыг хангахад зориулсан төсвийн эх үүсвэр, хөгжлийн тусламжийг чиглүүлсэн, (6) МХЗ-уудын хэрэгжилтэд хяналт тавих статистикийн тогтолцоог бүрдүүлсэн. Иймээс Монгол Улсын МХЗ-уудын хэрэгжилтийг эдгээр асуудлуудын хүрээнд авч үзэх нь зүйтэй.

МХЗ-уудын 24 зорилтоос 8 зорилт бүрэн биелсэн буюу биелэх боломжтой, 7 зорилтын хувьд нэмэлт арга хэмжээ авч, тодорхой хүчин чармайлт гаргавал 2015 он гэхэд хэрэгжих боломжтой, 3 зорилгын хүрээнд 4 зорилт үлдсэн хугацаанд хэрэгжих магадлал багатай, харин мэдээлэл, арга зүйн асуудлаас шалтгаалан 5 зорилтын хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

МХЗ-уудыг 2015 он гэхэд хангах үйл явц нь зарим тодорхой үзүүлэлтийн хувьд ахиц гарсныг онцлон харуулах боловч бүх саад бэрхшээлийг даван туулсан гэсэн үг биш юм. Тухайлбал, ихээхэн хүчин чармайлт гаргасны үр дүнд ядуурлыг 2 дахин бууруулах зорилтыг 2015 он гэхэд биелүүллээ ч гэсэн, хүн амын 18 хувь нь ядуурлын үндэсний шугамаас доогуур түвшинд амьдарсаар байх болно.

Ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бүх нийтэд суурь боловсрол олгох, жендерийн тэгш байдлыг хангах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах, агаарын бохирдлыг арилгах, засаглалыг бэхжүүлэх зэрэг зорилтыг 2015 он гэхэд бүрэн хангах боломж бага учир эдгээр МХЗ-уудыг хэрэгжүүлэх тал дээр 2015 оноос хойш хүч тавин ажиллах шаардлагатай байна.

### Саад бэрхшээл

Монгол Улс нь хөгжлийн олон саадыг даван туулах шаардлагатай тулгарч байна. 2012 оны 12 дугаар сараас 2013 оны 5 дугаар сар хүртэлх хугацаанд ЭЗХЯ-аас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан “Бидний хүсч буй ирээдүй” сэдэвт, 2015 оноос хойших хөгжлийн асуудлаарх Үндэсний хэмжээний цуврал хэлэлцүүлгийн үеэр дээрх бэрхшээлийн ихэнхийг авч хэлэлцсэн юм.

Уул уурхайд тулгуурлан Монгол Улсын эдийн засаг асар хурдтай өсч, дунджаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтах болжээ. Эдийн засгийн өсөлт нь ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой боловч Монгол Улсын бодлогын үндсэн сорилт нь ашигт малтмалаас олж буй орлогыг хүн арддаа хэрхэн зөв хүртээн хуваарилах, Монгол хүн бүрт хүрсэн, хүртээмжтэй өндөр өсөлтийг хангах вэ гэдэгт оршиж байна.

Ядуурал болон ажилгүйдлийг бууруулах нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал байсаар ирсэн. Нийтийг хамруулсан, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах стратегийг Засгийн газраас боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ядуу болон ядууралд өртөж болзошгүй хүн амын эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын болон даван туулах чадавхийг бий болгоход анхаарлаа онцгойлон хандуулах хэрэгтэй байна. Хавтгайруулсан халамж үзүүлж, бэлэн мөнгө тарааснаар ядуурал буурдаггүйг манай орны өнгөрсөн жилүүдийн туршлага харууллаа.

Эдийн засгийг төрөлжүүлэх, хувийн хэвшил, орон нутгийн бизнесийг дэмжин хөгжүүлэх нь чухал юм. Монгол Улс эдийн засгаа цаашид улам тэлж, бүтээмжтэй ажил эрхлэлтийг бүх талаар дэмжиж, ялангуяа залуучуудад зориулсан хөдөлмөр эрхлэлтийг орлох хувилбарыг бий болгох шаардлагатай байна. Дээд боловсролын салбарын өнөөгийн байдлыг хөдөлмөрийн зах зээл дэх чадавхитай ажилтны эрэлт болон нийлүүлэлт нийцэхгүй байгаагаар илэрхийлж болно. Олон улсад өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд өндөр чадавхитай боловсон хүчин бэлтгэх нь Монгол Улсын гол сорилтын нэг болжээ.

Хүүхдийн сурч боловсрох, эрүүл байх, ус, ариун цэврийн болон хоол тэжээлийн хангамж авах боломжийг сайжруулах нь Монгол Улсын нэг чухал асуудал юм. Үүнтэй нэгэн адил, хүүхдийн ядуурал, хүүхэд хамгаалал, уур амьсгалын өөрчлөлтөөс хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөө, тэдний гамшигт өртөмтгий байдал нь чухал асуудал байсаар ирсэн бөгөөд хүүхдийн эрх тэгш байдлыг хангах замаар нэмэлт анхаарал тавих шаардлагатай байна.

Эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болсон уул уурхайн салбараас байгаль орчинд ихээхэн дарамт учруулж байгаа тул байгаль орчны тогтвортой байдлыг эдийн засгийн өсөлттэй тэнцвэржүүлэх асуудал Монгол Улсад тулгарч буй бас нэгэн сорилт болж байна. Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, газрын хэвлийн баялгийг богино хугацаанд олборлож, уул уурхайн зарим компаниуд байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орхигдуулсанаас байгаль орчинд нөхөж баршгүй хохирол учирсаар ирсэн.

Уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, нүүрсхүчлийн хийн ялгарал, усны хомсдол, хөрсний доройтол, цөлжилт, биологийн олон янз байдлын хомсдол зэрэг байгалийн хүчин зүйлс Монголд хүчтэй нөлөөлөл үзүүлж, байгаль орчинтойгоо зохицон аж төрдөг иргэд, ялангуяа хөдөөгийн малчид, тариалан эрхлэгчдийн байгалиас хамаарах байдлыг нэмэгдүүлж байна. Тогтвортой хөгжлийн зэрэгцээ хариуцлагатай уул уурхайд шилжих, ногоон эдийн засаг, сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгөх шаардлагатай байна.

Монгол Улсын хүн амын 67 хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг. Хотын хүн амын 65 хувиас илүү нь нийгмийн хамгаалал, үндны усны баталгаат хангамж, сайжруулсан ариун цэврийн байгууламж, цахилгаан эрчим хүчний хангамж зэрэг дэд бүтэц хязгаарлагдмал гэр хороололд амьдарч, найдвартай бус ажил эрхэлж байна. Тогтвортой хотжилт, хотын ядуурлыг бууруулах асуудлууд Тогтвортой хөгжлийн талаарх НҮБ-ын Рио+20 Чүүлган болон 2015 оноос хойших хөгжлийн зорилтуудын хэлэлцүүлэг дээр хөндөгдсөн юм. Эдийн засгийн өсөлт болон хотын тогтвортой хөгжилд хөрөнгө оруулалт хийж, тулгарч буй саад тотгорыг дүгнэн шинжилж, оновчтой бодлогыг боловсруулах зэрэг нь Монгол Улсад тулгарч буй чухал асуудлуудын нэг юм.

Далайд гарцгүй орны хувьд Монгол Улс нь бүс нутгийн худалдааны сүлжээ, өмнөд-өмнөдийн болон гурван талт хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох нь эдийн засгийн аливаа хямралыг даван туулах чадавхийг сайжруулахад чиглэсэн мэдлэгийн суурийг өргөжүүлэхэд туслах болно.

Засаглал, эрх зүйн орчин, институцийн чадавхи болон хүний эрх зэрэг нь МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Монгол Улсад засаглалыг сайжруулах чиглэлээр авах шаардлагатай арга хэмжээ нь шүүх засаглалын шинэчлэл, авлигын эсрэг чиглэсэн, харагдахуйц шударга тэмцэл хийх замаар төрийн үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл болон хууль хэрэгжүүлэх зарчмыг баталгаажуулах явдал юм.

## **Дүгнэлт**

2001 оноос хойш МХЗ-үүд нь хөгжлийн хэлэлцүүлгийг үндэсний түвшинд бүрдүүлэх, дэлхийн нийтлэг зорилгуудыг хангахад чиглэсэн арга хэмжээ авахад түлхэц үзүүлсэн. МХЗ-уудыг хангасан байх цаг хугацаа ойртох тусам хэрэгжилтийн явцыг дүгнэхэд түлхүү анхаарч, 2015 оноос хойших хөгжлийн асуудлуудад анхаарал хандуулах болсон.

Зарим тодорхой нэмэлт арга хэмжээг авч чадвал **дэлхийн МХЗ-уудын 71 хувийг нь Монгол Улс 2015 он гэхэд хэрэгжүүлэхээр** байна.<sup>8</sup> МХЗ-уудыг бүрэн хангаж чадахгүй байх нь хэрэгжилт мүү байна гэсэн үг биш. Энэхүү Илтгэлд дурдсанчлан Монгол Улс 2001 оноос хойш олон МХЗ-уудыг амжилттай хэрэгжүүлж чадсан. Гэвч илүү ихийг хийх хэрэгтэй байна.

МХЗ-уудын хэрэгжилт нь түншлэл, оролцооноос хамаарах учир бодлогын түвшинд тодорхой шийдвэр болон хүчин чармайлт гаргах, салбар хоорондын уялдааг хангах, МХЗ-уудыг хэрэгжүүлэх болон 2015 оноос хойших хугацааны хөгжлийн сорилтыг даван туулахад иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, хувийн хэвшлийг өргөнөөр татан оролцуулах, тэдгээрийн хамтын ажиллагааг уялдуулах шаардлагатай байна.

МХЗ-уудын хэрэгжилт нь тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм. 2015 онд зорилтот түвшинд хүрсэн ч гэсэн эдгээр нь хөгжлийн зорилтууд байсаар байх болно. Тиймээс МХЗ-үүд нь эдийн засгийн өсөлтийн өгөөжийг Монгол хүн бүрт үргэлжлүүлэн хүртээх үйл ажиллагаа байх болно.

---

<sup>8</sup> Монгол Улсын онцгой зорилго тул МХЗ 9-ийн хэрэгжилтийн явцыг үнэлгээнд оруулаагүй болно.

## МОНГОЛ УЛСЫН МХЗ-УУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Зорилго/Зорилт/Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт					Зорилт
	1990	2000	2010	2011	2012	2015
<b>МХЗ 1: ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ</b>						
<b>Зорилт 1: Амьжиргааны доод түвшингөөс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах</b>						
1. Ядуурлын түвшин (хувь)	36.3 (1995)	35.6 (1998)	38.7	33.7	27.4	18.0
2. Ядуурлын гүнзгийрэлт (хувь)	10.9 (1995)	11.7 (1998)	11.5	9.2	7.1	6.0
3. Үндэсний нийт хэрэглээнд хамгийн бага хэрэглээтэй хүн амын хэрэглээний эзлэх хувийн жин	–	7.5 (2002)	7.9	7.8	7.7	11.0
4. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /оны үнээр, мянган төгрөг/	6.0	490.6	3072.5	3979.3	4883.3	6800.0
<b>Зорилт 2: Хоол, тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах</b>						
5. Тав хүртэлх насны тураалтай хүүхдийн эзлэх хувь	12.0 (1992)	11.6	3.3	–	–	2.0
6. Тав хүртэлх насны өсөлтийн хоцролттой хүүхдийн эзлэх хувь	12.0 (1992)	29.9	15.3	–	–	13.0
7. Тав хүртэлх насны туранхай хүүхдийн эзлэх хувь	–	7.1	1.6	–	–	1.0
<b>Зорилт 3: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах</b>						
8. Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	–	62.9	61.6	62.5	63.5	70.0
9. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин (хувь)	6.5 (1998)	4.4	19.5	15.6	14.0	2.5
<b>Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах</b>						
10. Хот, суурингийн нийт хүн амд хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын эзлэх хувь	–	–	–	–	–	0.0
<b>МХЗ 2: БҮХ НИЙТЭЭРЭЭ АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ</b>						
<b>Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох</b>						
11. Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	95.9 (1997)	95.0	94.7	94.8	95.2	100.0
12. Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь	91.0	83.6	92.9	93.2	94.5	100.0
13. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь	99.0 (1989)	97.7	98.5	–	–	100.0
<b>МХЗ 3: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ</b>						
<b>Зорилт 6: 2015 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах</b>						
14. Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.03 (1995)	1.01	0.96	0.95	0.95	1.00
15. Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.33 (1997)	1.20	1.07	1.06	1.07	1.00
16. Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа	–	1.72	1.48	1.43	1.40	1.00
<b>Зорилт 7: Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах</b>						
17. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь	51.1	50.4	47.5	46.5	47.8	50.0
<b>Зорилт 8: Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх</b>						
18. Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	24.9	11.8	3.9	3.9	14.7	30.0
19. Улсын Их Хуралд нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь	7.7 (1992)	10.9	18.5 (2008)	18.5	32.0	30.0
<b>МХЗ 4: ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ</b>						
<b>Зорилт 9: Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах</b>						
20. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	97.2	44.5	25.6	20.2	18.9	21.0

Зорилго/Зорилт/Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт					Зорилт
	1990	2000	2010	2011	2012	2015
21. Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	65.4	32.8	20.2	16.5	15.5	15.0
22. Улаан бүрхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь	82.3 (1991)	92.4	96.9	98.1	98.8	99.0
<b>МХЗ 5: ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ</b>						
<b>Зорилт 10: НҮЭМ-ийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах</b>						
23. Эхийн эндэгдлийн түвшин (100,000 амьд төрөлт тутамд)	121.6	166.3	47.4	48.7	51.5	50.0
24. Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь	100.0	99.6	99.8	99.8	99.7	99.0
<b>МХЗ 6: БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ, СҮРЬЭЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ</b>						
<b>Зорилт 11: 2015 он гэхэд ХДХВ-ийн халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх</b>						
25. Жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах ХДХВ-ын халдварын тархалт (хувь)	–	0.005 (2005)	0.003	0.004	0.002	<0.1
26. 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт (хувь)	–	0.0007 (2007)	0.0012	0.0005	0.0012	<0.1
<b>Зорилт 12: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах</b>						
27. Сүрьеэ өвчний тархалт (100,000 хүн тутамд)	435	60	65	60	59	82
28. Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100,000 хүн тутамд)	79	125	154	143	139	100
29. Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт (100,000 хүн тутамд)	5	3	3	2	2	2
30. Оношилгоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд сүрьеэг илрүүлж, эмчилсэн тохиолдлын хувь	31.0 (1994)	81.0	85.0	83.0	83.0	100.0
<b>Зорилт 13: Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах</b>						
31. 5-6 настай хүүхдийн шүд цоорох өвчний тархалт (хувь)	–	80.1 (2004)	–	–	–	75.0
<b>МХЗ 7: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>						
<b>Зорилт 14: Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот, суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх</b>						
32. Ойт нутгийн эзлэх хувь	–	–	8.26	8.03	8.03	9.0
33. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	–	13.1	14.56	16.41	27.69	30.0
34. Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар ислийн ялгаралт (тонн/хүн)	5.3	3.5	4.4	5.7	6.6	4.0
35. Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн өвлийн хоногийн дундаж агууламж (мкг/м3)	–	–	47.0	78.0	80.0	30.0
36. Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн өвлийн дундаж агууламж (мкг/м3)	–	–	41.1	50.0	52.0	20.0
<b>Зорилт 15: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах</b>						
37. Хамгаалалтад авсан гол, мөрний усны урсац бүрэлдэх ундаргын эхийн эзлэх хувь	–	–	38.7	45.3	–	80.0
38. Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандны эхийн тоо, өссөн дүнгээр	–	–	1,049	1,230	1,518	1000.0
<b>Зорилт 16: 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах</b>						
39. Баталгаат ундны усны хангамжгүй хүн амын эзлэх хувь	45.0	33.8	27.4	–	–	40.0
40. Сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувь	77.4	77.0	76.8	–	–	60.0
<b>Зорилт 17: 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах</b>						
41. Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь	–	22.7	21.2	–	–	30.0
<b>МХЗ 8: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</b>						
<b>Зорилт 18: Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх</b>						
42. Худалдааны хүчин чадлыг бий болгоход туслахаар үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	0.05	0.03	0.03	0.01	0.13	10.0
43. Нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	4.4 (1991)	11.9	19.5	25.9	26.3	5.0
44. Дотоодын нийт бүтээгдэхүүнд экспортын эзлэх хувь	33.4 (1991)	54.0	54.7	62.3	50.9	70.0

Зорилго/Зорилт/Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт					Зорилт
	1990	2000	2010	2011	2012	2015
45. Санхүүгийн гүнзгийрэл: Дотоодын нийт бүтээгдэхүүн, нийт мөнгөний харьцаа	44.0	21.1	55.6	57.8	54.6	65.0
<b>Зорилт 19: Далайд гарцгүй Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх</b>						
46. Үндэсний нийт орлогод хөгжлийн албан ёсны тусламжийн эзлэх хувь	23.2 (1991)	15.9	2.7	1.4	2.0	20.0
47. Төмөр замын ачаа тээвэрлэлтэд дамжин өнгөрөх ачааны эзлэх хувь	6.7	16.5	13.8	10.2	7.5	40.0
<b>Зорилт 20: Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судлаж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх</b>						
48. Дотоодын нийт бүтээгдэхүүнд Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь	37.3 (1991)	75.1	27.5	23.9	32.0	30.0
49. Экспортод Засгийн газрын гадаад өрийн эзлэх хувь	24.3 (1991)	139.1	50.2	38.4	74.8	40.0
50. Засгийн газрын орлогод гадаад өрийн эзлэх хувь	138.0 (1991)	265.6	76.3	86.5	90.1	60.0
51. Экспортод Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний эзлэх хувь	–	3.9	4.0	1.5	2.0	3.9
52. Засгийн газрын орлогод гадаад өрийн үйлчилгээний эзлэх хувь	1.6 (1991)	7.4	6.1	3.4	2.4	7.5
<b>Зорилт 21: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах</b>						
53. Сүүрин утасны цэгийн тоо (1,000 хүн тутамд)	31	47	52	47	53	100
54. Интернет байнгын хэрэглэгчдийн тоо (1,000 хүн тутамд)	–	2	73	164	245	30
55. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (1,000 хүн тутамд)	–	31	925	1,056	1,207	350
<b>МХЗ 9: ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ</b>						
<b>Зорилт 22: Хүний эрхийн түгээмэл түнхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох</b>						
56. Хүний хөгжлийн индекс	–	0.667	0.756	0.768	0.778	0.830
57. Монгол Улсын хууль тогтоомж олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцэд нийцэж буй талаарх шинжээчдийн үнэлгээ (хувь)	–	–	3.4 (2008)	–	3.9 (2011)	–
58. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт (хувь)	–	56.8 (2004)	51.9	72.3	75.1	–
59. Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо	–	507 (2004)	471	405	445	–
60. Улс төр, эдийн засаг, санхүүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хараат бус байдлын талаархи иргэдийн төсөөлөл	–	–	28.5	–	–	–
61. Төсөв, түүний зарцуулалтын тайланг вэб хуудсандаа тогтмол байрлуулдаг төрийн байгууллагын тоо	–	70 (2008)	88	165	345	–
<b>Зорилт 23: Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх</b>						
62. Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэдийн төсөөлөл	–	–	–	–	–	–
63. Улсын төсвийн төслийг боловсруулах, батлах үед саналаа албан ёсоор ирүүлсэн иргэний нийгмийн байгууллагын тоо	–	–	1	1	1	–
64. Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхэд оролцох иргэдийн ирцийн хувь	–	–	–	–	–	–
<b>Зорилт 24: Авлигыг үл тэвчих үүр амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх</b>						
65. Авлигын индекс	–	0.0	0.64 (2009)	0.63	0.0	–
66. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи төсөөлөл	–	0.0	4.1	4.1	3.9	–
67. Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагын хүрээнд дэх авлигын талаархи иргэдийн төсөөлөл	–	–	–	–	–	–



---

**ИЛТГЭЛИЙГ БЭЛТГЭСЭН БАГ**Эдийн засгийн хөгжлийн яам

Г.Батхүрэл  
О.Идшинрэнжин

Орчуулагчид

О.Энх-Ариунаа  
С.Төгсдэлгэр  
Д.Ариунаа  
Х.Хишигжаргал

Зөвлөхүүд

А.Гэрэлтуяа  
Б.Батмөнх

НҮБХХ Туслалцаа

П.Цэцгээ  
С.Саран  
Г.Дэлгэрмаа

Суурь Илтгэлийн  
урьдчилсан үнэлгээ  
бэлтгэгчид

Ч.Хашчулуун  
Ш.Мөнхцэрэн

Хянан тохиолдуулсан

Ж.Жаргалсайхан  
Саурабх Шина